



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 8/381

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засварын үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: 3.Балданням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Д.Сугар (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Ц.Оюун (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Ч.Өлзийхутаг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хурээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (3.Балданням)-д даалгасугай.

3.Төндер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Өлзийхутаг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0944

D:My Doc. Zahiramj. Zasag darga